

“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн  
хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүн, гишүүд  
“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тухай  
Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд  
Т.Бадамжунайн илтгэлийг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд

1. Хүнсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогод нийцүүлэн “Хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2012 онд багтаан хэлэлцэн батлах;

2. Хүнсний бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь хэмжээг уян хатан тогтоох, шаардлагатай үед өөрчилж байх эрхийг Засгийн газарт олгох эрх зүйн орчинг бүрдүүлэх.

Хоёр. Засгийн газарт

1. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн хоршсон цогцолборыг бий болгоход чиглэсэн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх;

2. Гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц болон хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах зорилго бүхий улирлын нөөцөд хамаарах хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг шинэчлэн тогтоож, түүнийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улын болон орон нутгийн төсөвт тусган нөөц бүрдүүлэх арга хэмжээг авах;

3. Инженерийн хийцтэй худаг, услалтын систем, цас, борооны усыг хуримтлуулах цөөрөм, усан санг шинээр барих, сэргээн засварлах ажлыг эрчимжүүлэх, хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, газар тариалангын усан хангамжийг нэмэгдүүлэх;

4. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавих хяналт, баталгаажуулалт, сорилт шинжилгээг олон улсын жишигт хүргэн итгэмжлэлд хамруулах;

5. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй хоол тэжээлийн дутлыг бууруулахад чиглэсэн баяжуулсан болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүний үйлдвэр, эмчилгээ сувиллын газар, бага насны хүүхдийн нэмэгдэл хоолны үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх;

6. Хүний эрүүл мэндийг дэмжих, импортын орлох, экспортын шинэ нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг бий болгоход чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагын чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ авах;

7. “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нэг бүрийн үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах болон олон улсын зээл, тусламж, төсөлд харилцан уялдаатайгаар, давхардалгүйгээр хамруулах замаар нэмэгдүүлэх арга хэмжээ авах.